



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/106

Мандалговь

Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.1, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уул уурхай, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх, орон нутгийн ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагааг сайжруулах, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Уянга

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Б.Бум-Очир

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Мөнхжаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Р.Цэрэндорж (Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч)

Э.Цэвэлмаа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хэлтсийн дарга)

Э.Эрдэнэтунгалаг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Ө.Удвал (Мерит төслийн Дундговь аймаг дахь зохицуулагч)

Э.Мөнхзул (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ж.Мөнхбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

2. Орон нутгийн аж ахуйн нэгж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, уул уурхайн компанийн хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх ажлыг үр дүнтэй шуурхай зохион байгуулж ажлын явцыг сар бүр тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Ж.Уянга)-т үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А/383 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100253